

“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 03/23

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1, “Булигаар хувьцаат компанийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. “Булигаар” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн үндсэн үйл ажиллагааны цэвэр ашгаас компанийн Хувьцаа эзэмшигчдэд олгох нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг 0.25 (тэг зууны хорин таван) төгрөгөөр тогтоосугай.
- Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
- Гурав. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүн болон хуулийн этгээдэд олгох ногдол ашгаас орлогын албан татварыг суутган тооцож, зөвхөн 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу компани дээр болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгосугай.
- Дөрөв. Ногдол ашиг хуваарилахтай холбогдох бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД